



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/11/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

“Төгс Нотолгоо аудит” ХХК-ийн захирал: Г.Цэцэгмаа
Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.03.15 № 89

танай _____-ны № _____-т

ОРХОН АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ С.ГАНДОЛГОР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын тайлант онд батлагдсан орлогын төлөвлөгөө 380,220.0 мянган төгрөгөөр тасарсан, зардал 131,521.8 мянган төгрөгөөр хэтэрсэн, мөнгөн хөрөнгө 73,324.5 мянган төгрөгөөр өсөж 75,139.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Авлага 241,377.6 мянган төгрөг, бараа материалын үлдэгдэл 116,488.4 мянган төгрөгөөр тус тус буурч, өр төлбөр 172,042.5 мянган төгрөгөөр өсөж, 510,477.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Насжилт өндөртэй 162,938.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Түүнчлэн тус байгууллагын бүртгэлд байгаа тээврийн хэрэгслүүд нь 1984-2008 оных ба элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үнэ цэнгүй 12 тээврийн хэрэгсэлтэй байгаа нь парк шинэчлэлт хийх талаар анхаарах шаардлагатай байна.

D:\my doc\alban bichig\2024-A4.doc

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 586 дугаар тогтоолыг үндэслэн Орхон АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор компанийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 15 бараа ажил үйлчилгээний 1,075,888.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 1,138.0 мянган төгрөгийн балансын ашигтай ажиллагаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 510,477.3 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажиллаж, төлөвлөсөн алдагдлыг 511,615.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын ажил төлөвлөгөөгөөр 117,650.0 мянган төгрөгөөр батлагдсанаас тайлант онд ажил хийгдээгүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 543,178.8 мянган төгрөгийн 3 ажилд 2 удаа нээлттэй тендер шалгаруулалт зарласан боловч оролцох компани байхгүй учраас 5 компанитай шууд худалдан авалтын гэрээ байгуулан бараа материал нийлүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Касс дахь мөнгөн хөрөнгө	14,185.62	327,112.0
1.1.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,815,156.16	74,812,628.11
1.1.3	Дансны авлага	411,160,268.31	169,782,603.97
1.1.4	Бараа материал	240,474,868.87	123,986,421.07
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,916,448.47	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	655,366,741.81	368,908,765.22
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	620,865,548.83	571,531,457.78
1.2.2	Биет бус хөрөнгө	1,200,000	-
1.2.3	Биологийн хөрөнгө	239,110.02	239,110.02
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	622,304,658.85	571,770,567.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,277,671,400.66	940,679,333.02
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	120,107,954.66	184,730,854.66
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	285,577,815.66	347,059,405.03
2.1.1.4	НДШ – ийн өглөг	63,000.00	47,507,620.46
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Бусад богино хугацаат өр төлбөр	4,614,532.19	3,107,923.55
2.1.1.9	Богино хугацаат өр төлбөрийн дүн	410,363,302.51	582,405,803.70
2.1.2	Бусад урт хугацаат өр төлбөр	626,893,956.00	626,893,956.00
2.1.3	Бусад богино хугацаат өр төлбөр	626,893,956.00	626,893,956.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,037,257,258.51	1,209,299,759.70
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: -төрийн	629,227,688.87	629,227,688.87
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	255,903,164.14	255,903,164.14
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-644,716,710.86	-1,153,751,279.69
2.3.10	Өмнөх үеийн үр дүн	-644,716,710.86	-643,273,945.40
2.3.11	Тайлант оны үр дүн	240,414,142.15	-268,620,426.68
2.3.12	Эздийн өмчийн дүн	3,958,208,556.83	4,512,076,071.71
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,277,671,400.66	940,679,333.02

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,763,722,21.82	1,481,570,978.98
2	Борлуулалтын өртөг	1,554,270,115.28	1,775,759,967.24
3	Нийт ашиг(алдагдал)	209,452,096.54	-294,188,988.26
4	Бусад орлого	37,786,197.92	12,729,764.55
8	Орлогын дүн	37,786,197.92	12,729,764.55
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	245,735,32.02	229,018,110.58
11	Санхүүгийн зардал	-	-
12	Зардлын дүн	245,735,32.02	229,018,110.58
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	1,502,922.44	-510,477,334.29
19	Орлогын татварын зардал	150,292.24	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,352,630.20	-510,477,334.29
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,352,630.20	-510,477,334.29
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-үлдэгдэл	629,227,688.87	255,903,164.14	-	-646,069,341.06	239,061,511.95
Залруулсан үлдэгдэл	629,227,688.87	255,903,164.14	-	-646,069,341.06	239,061,511.95
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,352,630.20	1,352,630.20
2022 оны 12-р сарын 31-үлдэгдэл	629,227,688.87	255,903,164.14		-644,716,710.86	240,414,142.15
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн алдааны залрууллага				1,442,765.46	1,442,765.46
Залруулсан үлдэгдэл			-		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-510,477,334.29	-510,477,334.29
2023 оны 12-р сарын 31-үлдэгдэл	629,227,688.87	255,903,164.14	-	1,153,751,279.69	-268,620.426.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,712,212,140.53,	1,892,579,623.31
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,061,688,430	1,873,928,491.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	165,988.00	3,933,765.00 ,
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	527,248,910.00	-
	Бусад мөнгөн орлого	123,108,902.53	14,717,367.31
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,755,654,419.64	1,819,255,039.29
	Ажиллагчдад төлсөн	404,630,452.27	468,455,827.59
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	110,587,274.81	90,063,000
	Бараа материал худалдан авахад төлсөн	698,505,090.00	766,689,964.00
	Ашиглалтын зардалд төлсөн,	14,950,72.10	13,095,740.89
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	444,736,201.00	351,383,720.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	9,557,718.46	41,712,065.52
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	54,829,462.00	84,980,826.29
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-43,442,279.11	73,324,584.02
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,110,500.00	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	6,110,500.00	
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-6,110,500.00	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,118,000.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	4,118,000.00	-
3.1.2	Төлсөн ногдол ашиг	1,050,00.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,050,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,068,000.00	-
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-46,484,779.11	73,324,58.02

6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48,299,935.27	1,815,156.16
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,1815,156.16	75,139,740.18

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д.д	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжээний нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 он		2024 оны төлөвлөгөө	Харьцуулалт (2023 гүй/төл)	
				төлөвлөгөө	гүйцэтгэл		Хувиар	Дүнгээр
1	Нийт орлого	мян.төг	1,801,508.4	1,874,520.8	1,494,300.8	2,213,000.0	79.7	(380,220.)
	Үүнээс: Улсын чанартай АЗЗА	мян.төг	1,171,034.8	1,074,520.8	1,071,709.8	1,363,000.0	99.7	(2,811.0)
	Орон нутгийн чанартай	мян.төг	630,473.6	800,000.0	422,591.0	850,000.0	52.8	(377,409.0)
2	Нийт зардал	мян.төг	1,800,005.8	1,873,256.3	2,004,778.1	2,212,647.4	107.0	131,521.8
	Удирдлагын зардалд	мян.төг	273,868.9	353,887.9	264,417.7	482,206.1	74.7	(89,470.2)
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	1,502.6	1,264.5	(510,477.3)	352.6	(40,369.9)	(511,741.8)
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	1,352.3	1,138.1	(510,477.3)	317.3	(44,855.4)	(511,615.4)
5	Төсвийн төлбөр	мян.төг	236,215.7	335,686.8	245,033.4	503,565.6	73.0	(90,653.4)
	а. Орлогын татварт	мян.төг	150.3	126.5	154.0	35.3	121.8	27.6
	б. НӨАТ	мян.төг	96,369.3	98,560.0	95,448.9	174,800.0	96.8	(3,111.1)
	в. НДШ	мян.төг	125,587.3	178,661.1	136,830.7	258,251.7	76.6	(41,830.4)
	г. ХХОАТатварт	мян.төг	7,590.5	52,160.6	7,608.1	64,300.0	14.6	(44,552.5)
	д. Үл хөдлөх хөрөнгийн татварт	мян.төг	2,247.9	2,247.9	913.9	2,247.9	40.7	(1,334.0)
	е. Газрын төлбөр	мян.төг	2,028.5	1,334.2	1,334.2	1,334.2	100.0	-
	ё. Тээврийн хэрэгслийн татварт	мян.төг	1,453.9	1,351.5	1,533.6	1,351.5	113.5	182.1
	ж. Бусад татварт	мян.төг	788.0	1,245.0	1,210.0	1,245.0	97.2	(35.0)
6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	1,050.0	1,050.0		500.0	-	(1,050.0)
7	Ажиллагсдын тоо	хүн	39.0	43.0	36.0	43.0	83.7	(7.0)
8	Цалингийн сан	мян.төг	520,193.9	654,436.1	551,727.2	945,977.0	84.3	(102,708.9)
9	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,111.5	1,268.3	1,277.1	1,833.3	100.7	8.9
10	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.99	0.99	1.34	0.99	135.5	0.4
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	6,110.5	117,650.0	-	13,150.0	-	(117,650.0)
12	Нийт авлага	мян.төг	411,160.3	173,000.0	162,938.1	173,000.0	94.2	(10,061.9)
13	Нийт өглөг	мян.төг	1,037,257.2	748,393.9	1,047,247.6	748,393.9	139.9	298,853.7
	Богино хугацаат өглөг	мян.төг	410,363.3	121,500.0	420,353.7	121,500.0	346.0	298,853.7

	Урт хугацаат өглөг	мян.төг	626,893.9	626,893.9	626,893.9	626,893.9	100.0	-
--	--------------------	---------	-----------	-----------	-----------	-----------	-------	---

Гурав. Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн буруу илэрхийллийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж/

Аудитаар нийт 2,410.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2,410.9 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- Тус байгууллагын мөнгөн кассын нярав нь 2,410.9 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"; Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын I хавсралт 3.7.6 "Бэлэн мөнгөний төлбөрийн картын дансаар энэ журмаар зөвшөөрснөөс бусад орлого, зарлагын гүйлгээ хийх; 3.8-т Мөнгөн кассын нярав нь анхан шатны орлого, зарлагын баримтыг үндэслэн мөнгөн кассын гүйлгээг хийнэ". 3.9. "Мөнгөн кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрт орлого, зарлагын баримтыг бичиж байна". Харин тусгай кассаар дамжин төвлөрсөн журмаар орох бараа, ажил үйлчилгээ болон үзвэр, үйлчилгээний орлого, цалин, тэтгэмж болон тусгай жагсаалтаар гаргах зарлага зэрэгт орлого, зарлагын төрөл тус бүрээр нэгдсэн нэг баримт бичнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн тул завсрын аудитаар залруулав.

Залруулаагүй алдаа:

Аудитаар нийт 28,138.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 28,138.0 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээний заалтыг үндэслэлгүй яамны болон сумын Засаг даргын шагналаар шагнагдсан албан хаагчдад тус бүр нь 30.0-100.0 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс гаргаж урамшуулсан, тайлант онд 19,875.5 мянган төгрөгийн хүнсний материалын тайлан гаргаагүй, санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, 1 албан хаагчид гадаад нислэгийн 7,372.5 мянган төгрөгийн зардал гаргасан боловч албан томилолтын хуудас, онгоцны тийз анхан шатны нотлох баримт байхгүй, тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 1,138.0 мянган төгрөгийн балансын ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 510,477.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан, хөрөнгө оруулалтын ажил 117,650.0 мянган төгрөгөөр батлагдснаас тайлант онд хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа, материал хүлээн авалтын баримтыг /НХМаягт БМ-1/ огт хөтөлдөггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 3.1-д "Бараа, материал хүлээн авалтын баримт" НХМаягт БМ-1 "Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирж байгаа бараа, материалын үнэ бүхий зүйлс, тоо хэмжээ, зэрэг дугаарын хувьд дагалдан ирсэн баримттайгаа тохирохгүй байх, хайрцаг, сав, баглаа боодол, лоц, ломбо задарч гэмтсэн үед эд хариуцагч санхүүгийн албанд мэдэгдэж байгууллагаас мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй комисс томилуулж "Бараа, материал хүлээн авалтын баримт"-аар хүлээн авна. Комисс "Бараа, материал хүлээн авалтын баримт"-ыг асуултын дагуу 2 хувь нөхөн бичиж 1 хувийг дагалдан ирсэн баримтын хамт эд хариуцагчид, үлдэх хувийг тээвэрлэгчид өгнө.", Эд хариуцагч "Бараа, материал хүлээн авалтын баримт"-аар агуулахын бүртгэлийг хөтөлж тайлангийн хамт тайлант хугацаанд санхүүгийн албанд ирүүлнэ. Хариуцсан нягтлан бодогч хураангуй дансанд бичилт хийж баримтыг хадгална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан маягтын дагуу анхан шатны баримтыг хөтлөж байх.

2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэх удирдлага, эд хариуцагч солигдох үед хөрөнгийн тооллого хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Гүйцэтгэх удирдлага, эд хариуцагч солигдох үед хөрөнгө, бараа материалын тооллого хийж байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон АЗЗА ТӨХК	1	2,410.9			1	2,410.9	1	2,410.9				
Дүн	1	2,410.9			1	2,410.9	1	2,410.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон АЗЗА ТӨХК	1	890.0			1	890.0						
	1	19,875.5			1	19,875.0						
	1	7,372.5			1	7,372.5						
	1	0			1	0						
	1	0					1					
	1	0					1					
Дүн	6	28,138.0			4	28,138.0	2	0	0	0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Орхон АЗЗА ТӨХК								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

